



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2018 оны 05 сарын 11 өдөр

Дугаар А/61

Улаанбаатар хот

Арилжаанд оролцох эрхийг хязгаарлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1 дэх заалт, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.10.11 дэх заалт, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн “Гишүүнчлэлийн журам”-ын 5 дугаар зүйлийн 5.2.3.2 дахь заалт, “Гишүүнчлэлийн гэрээ”-ний 2 дахь хэсэг 2.4.3.1, 2.4.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:


1. “Гишүүнчлэлийн журам”-аар хүлээсэн үүргээ биелүүлээгүй хавсралтад заасан нэр бүхий 6 компанийн үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг түр хязгаарлах арга хэмжээг 2018 оны 5 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн үүрэг биелэгдэх хүртэл хугацаанд авсугай.
2. Үнэт цаасны арилжааны програмд нэвтрэх эрхийг хязгаарлахыг Үйл ажиллагааны газрын Арилжааны алба /Д.Алдармаа/-нд, тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт зохицуулалтын газрын Хяналт шинжилгээний алба /Д.Баттулга/-нд тус тус үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Х.АЛТАЙ

“МХБ” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын
2018 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн
А/Б/ дугаар тушаалын хавсралт



**Үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг
түр хязгаарлах арга хэмжээ авагдах
гишүүн үнэт цаасны компаниудын нэрс**

1. "Алтан Хоромсог ҮЦК" ХХК
2. "Булган Брокер ҮЦК" ХХК
3. "Гацуурт Трейд ҮЦК" ХХК
4. "Масдак ҮЦК" ХХК
5. "Монгол Секюритиес ҮЦК" ХК
6. "Өндөрхаан Инвест ҮЦК" ХХК

---oOo---